



Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах

Үйлдвэрийн газрын зорилтыг биелүүлэхийн хүрээнд шаардлагатай ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор мэргэжил, ур чадвар, эзэмшсэн иргэнийг ажилд авахдаа холбогдох баримт бичгийг үндэслэн, үнэнч шударга байдал, мэргэжлийн дадлага туршлага, эзэмшсэн мэдлэг чадвар, эрүүл мэнд, сахилга бат зэргийг харгалзан хүний нөөцийг бүрдүүлнэ.

Ажилтныг сонгон шалгаруулахдаа дараах шатаар шалгаруулна:

- ❖ Анкетны сонгон шалгаруулалт
- ❖ Анхан шатны ярилцлага (Хүний нөөцийн ажилтан хийх)
- ❖ Дараагийн шатны ярилцлага (харъяалах Хэлтсийн дарга болон Захиргаа)

Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн дор дурьдсан бичиг баримт, материалыг бүрдүүлнэ.

Нийтийн тээврийн автобусны жолоочоос бусад ажлын байранд ажилд орох иргэн:

- ✓ Анкет
- ✓ Цээж зураг 3/4хэмжээтэй 6 хувь (сүүлийн 6 сарын дотор авахуулсан)
- ✓ Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээний хуулбар (нотариатаар батлуулах)
- ✓ Оршин суугаа хорооны тодорхойлолт
- ✓ Эрүүл мэндийн үзлэгийн хуудас
- ✓ Өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- ✓ Гурван үеийн товч намтар
- ✓ Урьд эрхэлж байсан ажлаас чөлөөлөгдсөн тушаалын хуулбар
- ✓ Ажилд орохын хүссэн өргөдөл

Шинээр ажилд орох нийтийн тээврийн автобусны жолоочид тавигдах шаардлага

1.Үйлдвэрийн газрын зорилтыг биелүүлэхийн хүрээнд шаардлагатай ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор мэргэжил, ур чадвар, эзэмшсэн иргэнийг ажилд авахдаа холбогдох баримт бичгийг үндэслэн, үнэнч шударга байдал, мэргэжлийн дадлага туршлага, эзэмшсэн мэдлэг чадвар, эрүүл мэнд, сахилга бат зэргийг харгалзан хүний нөөцийг бүрдүүлнэ.

1.1.Жолоочоор ажилд орох иргэн нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- ❖ Анкет
- ❖ Өргөдөл
- ❖ Жолооны үнэмлэх, иргэний үнэмлэх, мэргэшсэн үнэмлэхний хуулбар /нэг цаасан дээр хуулбарласан байх/
- ❖ Хоёр үеийн намтар /өөрийн, эцгийн/
- ❖ Хорооны тодорхойлолт
- ❖ Эрүүл мэндийн хуудас
- ❖ Цээж зураг 4%
- ❖ Жолоодох эрхийн лавлагаа
- ❖ Мэргэшсэн үнэмлэхний лавлагаа
- ❖ Даатгал /мэргэшсэний/
- ❖ Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт /e-mongolia/
- ❖ Ажлаас чөлөөлөгдсөн тушаал

2.Шинээр ажилд орж буй жолооч нь 2 хоног баазын засварын үйл ажиллагаатай танилцаж ажиллах

3.Засварт ажиллах хоног дууссаны дараа шугамтай танилцах зорилгоор дагалдан жолоочоор 1-3 хоног ажиллах

4.Баазын ажилтай танилцах хугацаа дууссаны дараа хэсгийн даргын саналыг үндэслэн тушаалаар ажилд томилж, шугамын үйлчилгээнд гаргана.

...oOo...